



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/170

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журамд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1, 122.2 дахь хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудад 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний 8.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журамд доор дурдсанаар нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

1.1.Хөдөлмөрийн дотоод журамд доор дурдсан агуулгатай 8.5¹, 8.5² дахь хэсэг нэмсүгэй:

"8.5¹.Ажилтны Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын иргэний нисэхийн асуудал хариуцсан нэгжид ажилласан хугацаа; Засгийн газрын шийдвэр, концессын зүйл, байгууллагын шийдвэрээр агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад ажилласан хугацаа нь энэ журмын 8.3, 8.4-т заасан хугацаанд нэгэн адил хамаарна.

8.5².Энэ журмын 8.5¹-д зааснаас бусад тохиолдолд ажилтан ИНЕГ, түүний харьяа салбар, нэгжид сүүлийн 3 жил тасралтгүй ажилласан бол тухайн ажилтны агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад ажилласан хугацаа нь энэ журмын 8.3, 8.4-т заасан хугацаанд нэгэн адил хамаарна."

1.2.Хөдөлмөрийн дотоод журмын 6.20.3 дахь заалтын "Ажилтан хүсэлт гаргасан тохиолдолд" гэсний дараа "нэгжийн даргын саналыг харгалзан" гэж, 6.22 дахь хэсгийн "Ажилтан чөлөөний" гэсний дараа "хуудас болон гадуур ажлын" гэж тус тус нэмсүгэй.

1.3.Хөдөлмөрийн дотоод журмын 4.5, 5.29, 6.3, 7.10, 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"4.5.Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулахаас өмнө Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан нэгж нь ажилтанд биечлэн, эсхүл албаны цахим хаяг, эсхүл ажилтны хувийн хэрэгт бүртгэгдсэн цахим хаяг, эсхүл гар утас, эсхүл шуудангаар мэдэгдэнэ. Ажилтнаас тайлбар авч, сахилгын зөрчлийн шинж, үр дагаврыг харгалзан энэ журмын 4.1-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэлийг сонгож хэрэглэнэ. Хариу тайлбарыг ажлын 3 өдөрт багтаан ирүүлэх ба ирүүлээгүй нь шийдвэр гаргахад нөлөөлөхгүй.

17120 1521

5.29.ИНЕГ-ын даргын эзгүйд түүний ажил, үүргийг албан тушаалын (ажлын байрны) тодорхойлолтоор орлох үүрэг хүлээсэн ажилтан, эсхүл тушаалаар түр орлож буй ажилтан гүйцэтгэнэ.

6.3.Ажилтан нь гадуур ажиллах тохиолдолд шууд харьяалах нэгжийн даргад мэдэгдэж, "Гадуур ажлын хуудас"-аар, эсхүл байгууллагын Дотоод удирдлагын нэгдсэн "iMCAA" системээр баталгаажуулж, Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ. Цагийн бүртгэлийн системд бүртгүүлээгүй, "Гадуур ажлын хуудас"-ыг хүргүүлээгүй бол ажил тасалсанд тооцно.

7.10.Харьяа салбар, нэгжийн удирдах ажилтнуудын үр дүнгийн нэмэгдлийг "Үр дүнгийн нэмэгдэл олгох жагсаалт"-ын дагуу шийдвэрлэнэ. Уг жагсаалтыг ИНЕГ-ын дарга батална.

8.2.Ажилтан тэтгэвэр тогтоолгох эрх үүсэж, тэтгэвэрт гарах үед ИНЕГ, түүний харьяа салбар, нэгжид ажилласан хугацаанаас хамаарч дараах тэтгэмжийг тэтгэвэр тогтоолгосон нөхцөлөөр нь тооцон олгоно."

1.4.Хөдөлмөрийн дотоод журмын 6.20.3 дахь заалтын "3 сар" гэснийг "1 жил" гэж, 7.12.2 дахь заалтын "8 цаг" гэснийг "240 минут" гэж, 11.2 дахь заалтын "нэгжүүдэд" гэснийг "нэгжийн хэмжээнд" гэж тус тус өөрчилсүгэй.

2.Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тус журмын 12 дахь хэвлэлд тусгаж, эх бэлтгэн хэвлүүлэх, нийт ажилтанд танилцуулж, харагдахуйц газар байршуулахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан), харьяа салбар, нэгжийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаалыг 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



С.МӨНХНАСАН